



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 317

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Улсын Их Хурлын 1999 оны Монголын уламжлалт анагаахыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үнэлгээний удирдамжийг хоёрдугаар, үнэлгээний төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ын үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлөөр 2015 оны 3 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

031101



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн ЭМСЯ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
- Нарийн бичгийн даргад: Н.Цогзолмаа, ЭМСЯ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн
- Гишүүд:
- Л.Зэндмаа, ЭМСЯ, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
 - Н.Тунгалаг, ЭМСЯ, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэслтийн мэргэжилтэн
 - Д.Нацагдорж, Уламжлалт анагаах ухааны салбар зөвлөлийн дарга, Манба дацангийн хамба лам, зөвлөх оточ
 - Ч.Чимэдрагчаа, Уламжлалт анагаахын шинжлэх ухааны технологи, үйлдвэрлэлийн корпорацийн захирал
 - Д.Шинэтуяа, Уламжлалт анагаахын шинжлэх ухааны технологи, үйлдвэрлэлийн корпорацийн эмнэлгийн дарга

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 08 сарын 19 өдрийн
31-д дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

**“МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС
БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
УДИРДАМЖ**

Үндэслэл

“Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого” нь 1999 оноос хэрэгжиж 2003 он, 2009 онд үнэлэгдэж 2015 онд дуусгавар болж байна.

Зорилго

Хөтөлбөрийн эмийн талаар мөрдөх хууль эрх зүйн орчин, лабораторийн хүчин чадлыг сайжруулах, олон нийтэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг олгох, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн боловсронгуй болгох үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийх

Үйл ажиллагаа:


1. Үнэлгээний ажлын хэсэг байгуулах, арга хэмжээний үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний хуваарь гаргах, үйл ажиллагааны тайланг хүлээн авах
2. Үнэлгээний хуваарийн дагуу байгууллага, аймаг орон нутгийн Эрүүл мэндийн газар, Уламжлалт анагаах ухааны төвүүдэд очиж үйл ажиллагаатай танилцах, үнэлэх
3. “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
4. Үнэлгээний тайланг гаргаж Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх, шийдвэрийн төсөл боловсруулах

Үнэлгээ хийх хугацаа: 2015 оны 9 сарын 1-ээс 15-г хүртэл

Гарах үр дүн: Стратегийн хэрэгжилтийн үр дүн гарна.

Эрүүл мэнд, спортын сайдын

2015 оны 08 сарын 19 өдрийн
317 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт



**“МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС
БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУВААРЬ**

№	Үйл ажиллагаа	8 сар	9 сар
1	Ажлын хэсгийн тушаал батлах, ажлын хэсгийн нэгдсэн хурал зохион байгуулах		
2	Үнэлгээний санхүүжилт, хөдөө орон нутгийн хуваарь гаргах		
3	Нэгдсэн үнэлгээ хийх аргачлал гаргах, үнэлгээ хийх		
4	Орон нутагт үнэлгээ хийх		
5	Үнэлгээний дүнг нэгтгэх		
6	ЭМСЯ-ны УЗ-ийн хуралд танилцуулах		